

ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ДАНЖААД ОВОГТОЙ ЭНХБАТЫН СОНГУУЛИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Энэхүү мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудын хүрээнд боловсруулагдсан ба хэрвээ ИТХ-д сонгогдсон тохиолдолд төлөөлөгчийн хувьд Эрдэнэт хотод шударга ёсыг тогтоож, шинэ үйлдвэрүүд бүтээн байгуулах, байгалийн баялагийг “33 34 33” загвараар шударга хуваарьлаж, дундаж давхаргыг босгох ажлууд мөн тухайн нэр дэвшигчийн нэр дэвших баг дээр хийж хэрэгжүүлэх, шийдвэрлэх зорилтуудыг тодорхойлсон.

Миний уриа

ЭРДЭНЭТИЙН ХӨГЖИЛД ЭРДЭНЭ ХОТЫН ИРГЭД БИД ОРОЛЦОНО !!

1.Эрдэнэт - Иргэддээ үйлчилдэг хот

1.1 .Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй цахим хэлбэрт шилжүүлэх

1.2.Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгуулллагуудын ажилтнуудын ажлын уялдаа холбоог сайжруулж иргэдэд түргэн шуурхай үйлчлэх боломжийг хангана.

2. Иргэдийн оролцоотой хөгжих “Эрдэнэт хот”

2.1 Уул уурхай дагасан Монгол улсын ууган хотын хувьд “Ногоон Эрдэнэт” жишиг хот төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх

2.2 Аюулгүй Ухаалаг хот төлөвлөлт / дэд бүтэц, инженерийн байгууламж /

2.3 Гадаадад ажиллаж, суралцаж буй Эрдэнэтчүүдийг төрөлх хотынхоо хөгжилд татан оролцуулах “Эрдэнэтдээ ирцгээ” хөтөлбөр хэрэгжүүлэх

3. Эрдэнэт - Үйлдвэрийн хот


Мэргэжлийн боловсролын тогтолцоог Эрдэнэт – үйлдвэрийн хотоосоо ажлын байр, шинэ бизнес эхлүүлэх боломжтой уялдуулан шинэчлэх замаар ажилтай орлоготой бүтээгч иргэдэд ажлын байр олноор бий болгох тусгайлсан бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.Үүнд;

3.1 “Эрдэнэт –Зэс эрдэнийн хот ”- Зэс бүтээгдхүүний төрөлжсөн үйлдвэрийн хот

3.2 Эрдэнэт үйлдвэрийн хэрэгцээг хангах - ЖДҮ

3.3 МАА –н түүхий эд боловсруулах - ЖДҮ зэрэг төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

3.4 Мэдээлэл технологийн гарааны бизнесийн эко системийг бүрдүүлэх



4. Эрүүл чийрэг иргэдтэй – Эрдэнэт хот

4.1. Эрүүл мэнд, биеийн тамир, спортын тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, өвчнийг эрт илрүүлэх, оношлох, үйлчилгээ үзүүлэх талаар, менежментийн орон зайг бий болгох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх .

4.2 “Эрүүл чийрэг Эрдэнэтчүүд” амьдралын зөв дадлыг дэмжсэн орчинг бүрдүүлэх

5. Эрдэм мэдлэгтэй залуусын хот

5.1. “Орос,Англи хэлтэй Эрдэнэт хот” төслийг хэрэгжүүлэх

Мөрийн хөтөлбөрийг боловсруулсан



..... Д.Энхбат

